

Энэхүү ТМТ нь 2015 оны 9 сарын 30-ны Англи хувилбарын орчуулга болно.



Монгол Улс: Баруун бүсийн бага сургуулийн дотуур байрны орчинг сайжруулах төсөл

Төслийн нэр	Баруун бүсийн бага сургуулийн дотуур байрны орчинг сайжруулах төсөл
Төслийн дугаар	49168-001
Улс орон	Монгол Улс
Төслийн статус	Санал
Төслийн төрөл / Тусламжийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Хөрөнгийн эх үүсвэр / Хэмжээ	Буцалтгүй тусламж: Баруун бүсийн бага сургуулийн дотуур байрны орчинг сайжруулах төсөл Ядуурал бууруулах Японы сан 3 сая ам.доллар
Стратегийн зорилт	Байгальд ээлтэй тогтвортой хөгжил Оролцоог хангасан эдийн засгийн өсөлт
Хөдөлгөгч хүчин зүйл	Засаглал ба чадавхийн хөгжил Мэдлэгт суурилсан шийдлүүд Түншлэлүүд
Салбар / Дэд салбар	Боловсрол – Боловсролын салбарын хөгжил
Жэндрийн тэгш байдал ба оролцоо	Жэндрийн оролцоог үр дүнтэй хангана
Агуулга	
Төслийн үндэслэл ба Улс/Бүсийн стратегитай уялдсан байдал	
Үр нөлөө	Сургуулийн дотуур байрны тогтолцоо шинэчлэгдэж, чанартай боловсролын тэгш хүртээмжийг сайжруулна (БСШУЯ-ны 2012-2016 оны Боловсролын салбарын шинэтгэлийн бодлого) Суурь боловсролд бүх нийтээр хамрагдах зорилт биелнэ (Монгол Улсын МХЗ-д суурилсан Үндэсний хөгжлийн цогц стратеги)
Үр дагавар	Баруун бүсийн 3 аймагт сургуулийн дотуур байрны орчин, үйлчилгээг сайжруулах загвар бий болно

Үр дүн

1. Сургуулийн дотуур байрны орчин, нөхцөл сайжирна

2. Сургуулийн дотуур байрны үйлчилгээ сайжирна

3. Сургуулийн дотуур байрны орчинг сайжруулахад чиглэсэн бодлого, эрх зүйн орчин бий болно

Газарзүйн байрлал

Газарзүйн байрлал

Байгаль орчин

С

Албадан нүүлгэн шилжүүлэлт

С

Уугуул иргэд

В

Байгаль орчин, нийгмийн асуудлын товчоон

Байгаль орчны асуудал Байгаль орчны асуудлын хувьд тус төслийг “С” ангилалд багтаасан. Төслийн Үр дүн 1-ийн хүрээнд, сургуулиудын дотуур байранд бага хэмжээний засвар, өргөтгөлийн ажил хийгдэх бөгөөд тэдгээр нь байгаль орчинд нөлөөгүй эсвэл маш бага сөрөг нөлөө үзүүлнэ.

Төслийн байгаль орчны нөлөөллийг хянан нягтлах бөгөөд Монгол Улсын байгаль орчны үнэлгээний хууль тогтоомжинд нийцүүлэн барилгын ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, ашиглалтын үед даган мөрдөх байгаль орчны менежментийн ерөнхий төлөвлөгөө (БОМТ)-г боловсруулах болно. Энэхүү ерөнхий БОМТ-г БТХГА-д багтаах бөгөөд сургуулийн үйл ажиллагаанд саад болохгүйгээр барилгын ажлыг төлөвлөх, гарсан санал шүүмжлэлийн дагуу арга хэмжээ авах журам зэрэг ажил гүйцэтгэх гэрээнд оруулах байгаль хамгаалалтай холбоотой заалтуудыг мөн тусгана.

Албадан нүүлгэн шилжүүлэлт

Төслийн хувьд газар хураан авах эсвэл оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх шаардлага гарахгүй тул албадан нүүлгэн шилжүүлэлтийн асуудлын хувьд “С” ангилалд хуваарилсан болно.

Уугуул иргэд

Уугуул иргэдийн асуудлын хувьд тус төслийг “В” ангилалд багтаасан болно. Төслийн хүрээнд, нүүдэлчин ахуй амьдралтай хэд хэдэн үндэстэн ястан оршин суудаг Увс аймгийн сургуулиудын дотуур байр, орон нутгийн захиргаа, боловсролын газрын хувьд эерэг үр дагавар авчирна. Үндэстний цөөнх болон малчин өрхүүдтэй холбоотой үүсч болзошгүй асуудлыг судалж, ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төслийн үр ашгаас хүртэх боломжийг нь сайжруулахад чиглэсэн арга хэмжээг төслийн төлөвлөгөөнд оруулна.

Оролцогч талуудын харилцаа, оролцоо ба зөвшилцөл

Төслийн төлөвлөлтийн үед	Үндсэн оролцогч талууд болох төрийн захиргааны байгууллагууд, аймгийн захиргаа, сургуулийн удирдлага, дотуур байрны ажилтнууд, бага сургуулийн багш, сурагчид, эцэх эх, малчин айл өрх, үндэстний цөөнх бүлгүүдийн төлөөлөлтэй зөвшилцөх ажил хийгдсэн бөгөөд хэлэлцүүлгийн үр дүнг төслийн төлөвлөгөөнд тусгасан болно.
Төслийн хэрэгжилтийн үед	Төслийн жилийн төлөвлөгөө, төсөв болон улирал, жилийн тайланг Төслийн удирдах хороо болон дэд хороод улирал тутам хэлэлцэх замаар төвийн болон орон нутгийн захиргааны байгууллагаас төслийн явцыг хянах болно. Дотуур байрны засварын явц, сурагчид эсвэл багш нарын санаачилсан сургалт, ном унших зэрэг хичээлээс гадуурх үйл ажиллагааны талаарх зар мэдээллийг дотуур байранд амьдарч буй сурагчдад дотуур байрны багш нар хүргэх бөгөөд харин бага сургуулийн сурагчдад багш нар нь хичээлийн жилийн түршид тогтмол давтамжтайгаар хүргэнэ. Дотуур байранд амьдарч буй сурагчдын эцэх эхчүүдэд зориулан сургуулийн удирдлага, дотуур байр, бага сургуулийн багш нар наад зах нь жилд нэг удаа зохион байгуулалттай арга хэмжээ явуулж, дотуур байрны засварын явц, сурагчид болон багш нарын санаачилсан сургалт, ном унших зэрэг хичээлээс гадуурх үйл ажиллагааны талаарх зар мэдээллийг хүргэнэ. Төслийн хүрээнд нэвтрүүлсэн дотуур байрны орчин, үйлчилгээний шинэ стандарт, шинэчилсэн үүрэг хариуцлага, санхүүгийн бодлогын талаарх мэдээллийг сургалт, семинар, гарын авлагаар дамжуулан дотуур байрны ажилтан, багш, сургуулийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад хүргүүлнэ.
АХБ-ын хариуцсан Асако Маруяма Ажилтан	
АХБ-ны хариуцсан Зүүн Азийн Газар (ЗАГ) Газар	
АХБ-ны хариуцсан Хот Төлөвлөлт, Нийгмийн Салбарын хэлтэс, ЗАГ Хэлтэс	
Хэрэгжүүлэгч агентлаг	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам , Засгийн газрын байр - III, # 514, Бага тойруу - 44, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Хуваарь	
Концепцийг батлах	2015 оны 7 сарын 2
Урьдчилсан судалгаа	2015 оны 5 сарын 28-6 сарын 15
Менежментийн хяналтын уулзалт	2015 оны 7 сарын 21
Батлагдсан	2015 оны 11 сарын 25
Сүүлд хийсэн хяналт	-
Сүүлд хийсэн нэмэлт	2015 оны 9 сарын 17

Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)–д төсөл болон хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл багтдаг: ТМТ нь одоогоор хэрэгжиж байгаа ажлын тухай байдаг тул тайлангийн анхны хувилбарт зарим мэдээлэл багтаагүй байж болох ба бэлэн болсон үед нь нэмж оруулдаг. Санал болгож байгаа төслийн талаарх мэдээлэл нь урьдчилсан бөгөөд тойм шинж чанартай.

АХБ нь энэхүү Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)–г хэрэглэгчдэд гагцхүү мэдээллийн чанартай хүргэж байгаа бөгөөд ямарваа нэгэн амлалт, баталгаа өгөхгүй. АХБ нь өндөр чанарын мэдээллийн контент гаргахыг эрмэлзсэн хэдий ч тухайн мэдээллийг “байгаагаар нь” ойлговол зохих бөгөөд арилжааны шаардлагыг хангах, тодорхой зорилгоор ашиглахад нийцэх эсвэл бусдын эрхэд халдахгүй байх гэх мэт ямарваа нэгэн шууд болон шууд бус баталгааг өгөхгүй. Нэн ялангуяа, тайланд агуулагдсан мэдээлэл үнэн зөв бөгөөд бүрэн бүтэн болох талаар ямар нэгэн баталгаа эсвэл мэдэгдэл гаргаагүй болно.